

Бусад баримт бичгүүд:

1. “Независимая газета.”

2. Указ Президента Российской Федерации от 15 октября 1999 г. ,1371 “О порядке присвоения и сохранения дипломатических рангов и об установлении ежемесячной надбавки к должностному окладу за дипломатический ранг”

3. Положение о Министерстве иностранных дел Российской Федерации, утверждёнno Указом Президента Российской Федерации от 11 июля 2004 г. , 865

4. Указ Президента Российской Федерации от 11 сентября 2007 года, 1163

5. Федеральный закон Российской Федерации от 27 июля 2010 г. N 205-ФЗ “Об особенностях прохождения федеральной государственной гражданской службы в системе МИД Российской Федерации”

Интернет эх сурвалж :

[www.mid.ru](http://www.mid.ru)

[www.wikipedia.ru](http://www.wikipedia.ru)

## **ОХУ-ЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ, СТРАТЕГИ**

Доктор Ph.D А.Нямдолжин\*

Өнгөрсөн зууны сүүл үеэс эхэлсэн шилжилтийн тэр үеэс өнөөг хүртэл Оросын төрөөс дэлхий нийтийн жишгийн дагуу боловсролын салбарынхаа үндсэн зарчим, зохион байгуулалт, чиг хандлагаа өөрчлөн, боловсруулан хэрэгжүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж иржээ. Энэ хугацаанд “Оросын боловсролыг шинэчлэх үзэл баримтлал” (2001-2010), “ Үндэсний тэргүүлэх төсөл “Боловсрол” (2005), “2006-2010 онд боловсролын тогтолцоог хөгжүүлэх зорилтот хөтөлбөр”, “Инновацийн Оросын шинжлэх ухаан ба шинжлэх ухаан-сурган хүмүүжүүлэх боловсон хүчнийг хөгжүүлэх зорилтот хөтөлбөр” (2009-2013), “Холбооны улсын боловсролын

*\*А.Нямдолжин – Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор (Ph.D)*

хөгжлийн зорилтот хөтөлбөр” (2011-2015) зэрэг баримт бичгүүд батлагдан хэрэгжиж байна.

Оросын боловсролын тогтолцооны хөгжлийн үндсэнд гадаадын эрэлт хэрэгцээнд боловсролыг нээлттэй болгох, төслийн аргыг хэрэглэх, практикт шинэ хандлагуудыг хэрэгжүүлэх, манлайлагчдыг дэмжих, сонгон шалгаруулалтаар гаргаж ирэх, шийдвэр гаргах цогц шинжүүдийг гаргах зэрэг зарчмууд тавигдаж байна.

Оросын засгийн газраас боловсролын салбарын стратегийн гол зорилгыг тодорхойлохдоо мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийн шаардлага, иргэн ба нийгмийн орчин үеийн хэрэгцээнд нийцсэн чанартай боловсролын хүртээмжийг дээшлүүлэх явдал бөгөөд энэ зорилгыг хэрэгжүүлэхэд мэдлэгт суурилсан хөгжлийн бодлоготой уялдуулан боловсролын байгууллагуудын сүлжээний бүтцийг шинэчлэх, их, дээд сургуулиуд дахь эрдэм шинжилгээ судалгааны санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, их, дээд сургуулиудын аж ахуйн бие даасан байдлыг дэмжих, дээд боловсролын санхүүжилтийг улсын төсвөөс бүрдүүлээд зогсохгүй, төсвийн гадна эх үүсгүүрээс бүрдэх нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн байдал, эрүүл мэндийн байдал, оршин суугаа газраас үл хамааран хүүхдийн эрт үеийн хөгжлийг хангах боловсролын үйлчилгээний тогтолцоог бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх, чанартай хүртээмжтэй боловсролын орчинг бүрдүүлэх, авъяаслаг хүүхэд, залуучуудыг дэмжих, авъяас, чадварыг нээх тогтолцоог бий болгох, боловсролын үйлчилгээний тухай иргэдэд үнэн зөв, цаг тухай бүрд нь шинэчилсэн, хүн бүрд хүрсэн, бүрэн дүүрэн мэдээллээр хангах мэдээллийн нээлттэй, шууд тогтолцоог байгуулах, боловсролын чанарын үнэлгээ, хяналтанд нийгмийн институтууд, хэрэглэгчдийн оролцооны механизмыг бий болгох зэрэг асуудлуудыг шийдвэрлэхээр заасан байна.<sup>1</sup>

2001 оноос хэрэгжиж эхэлсэн “Оросын боловсролыг шинэчлэх үзэл баримтлал” 2010 онд дуусч, Үндэсний тэргүүлэх төсөл “Боловсрол”, “Инновацийн Оросын шинжлэх ухаан ба шинжлэх ухаан-сурган хүмүүжүүлэх боловсон хүчнийг хөгжүүлэх зорилтот хөтөлбөр”-ийн хүрээнд түүний үндсэн чиглэлийг “Манай шинэ

сургууль” хэмээх Ерөнхийлөгчийн санаачилсан үндэсний боловсролын хөтөлбөр үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн гол зорилго нь Орос улсын эдийн засгийн технологийн ирээдүйг тодорхойлох зах зээлд дээд зэргийн эрэлт хэрэгцээтэй, дэлхийд өрсөлдөх чадвартай боловсон хүчин бэлтгэх явдал юм. Энэ үйл хэрэгт дунд сургууль чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Дунд сургуулийн боловсролын системийг хөгжүүлэх энэхүү “Манай шинэ сургууль” хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх гол ажил бол сурагч бүрийн авьяас чадварыг нээн гаргах, санаачилгатай бүтээлчээр сэтгэх, мэргэжлийн замаа зөв сонгох, шинжлэх ухаан, технологийн эрин зуунд амьдрахад бэлтгэх, эх оронч, төв шударга хувь хүнийг хүмүүжүүлэхэд оршиж байна. Үүнтэй уялдан XXI зууны орчин үеийн шинэ сургуульд өөрийн заах хичээлээ чадварлаг эзэмшсэн, өндөр мэдлэгтэй, сурагчдын сурах, нийгэмд эзлэх байр сууриа олох, бие даасан байдал, өөртөө итгэх итгэлтэй, амьдралын ямар ч нөхцөл байдал тулгарсан даван туулж, аливаа асуудлыг шийдвэрлэх чадварыг эзэмшүүлэх сурган хүмүүжүүлэгч шаардлагатай ба шинэ сургууль нь орчин үеийн эрэлт хэрэгцээ, сурагчдын эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, сурах таатай нөхцөл, сонирхлыг нь татсан архитектурын болон дизайны өвөрмөц шийдэл бүхий, шинэлэг технологи нэвтэрсэн тоног төхөөрөмжөөр номын сан, интернетийн танхим болон биеийн тамирын заалыг тоноглогсон, бүх сурагчдыг нэг зэрэг хүлээн авч эрүүл хоолоор үйлчлэх тохилог хоолны газартай сургууль байх юм.

“Манай шинэ сургууль” санаачилгыг хэрэгжүүлснээр иргэд орчин үеийн чанартай ерөнхий боловсрол олгох улсын болон хувийн сургуулийг сонгон суралцах эрхээр хангагдах үндэс тавигдаж байна. Юуны өмнө хөгжлийн бэрхшээлтэй, амьдралын хүнд нөхцөлд амьдардаг хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох таатай нөхцлөөр хангах үүднээс иж бүрэн, саадгүй орчинг сургууль болгонд бий болгон эдгээр хүүхдүүдийг амжилттай нийгэмших нөхцлийг бүрдүүлэх юм.

2005 оны 9-р сарын 5-нд Ерөнхийлөгч В.Путин Төрийн Зөвлөлийн тэргүүлэгчдийн болон Холбооны хурал дээр “Боловсрол”,

“Эрүүл мэнд”, “Хүртээмжтэй орон сууц”, “Газар тариалан, аж үйлдвэрийн цогцолборын хөгжил” гэсэн 4 үндэсний тэргүүлэх төслийг эхлүүлэхээр зарлаж, нэгдүгээрт, чухамхүү эдгээр салбарууд нь хүн амын амьдралын чанар, нийгмийн байдлыг тодорхойлно. Хоёрдугаарт, эцсийн дүндээ эдгээр асуудлуудыг шийдвэрлэснээр улс орны хүн ам зүйн нөхцөл байдалд шууд нөлөөлж, хүний капиталыг хөгжүүлэх зайлшгүй нөхцөлийг бүрдүүлнэ хэмээн тэмдэглэжээ.<sup>2</sup>

Үндэсний тэргүүлэх “Боловсрол” төсөл нь оросын боловсролын тогтолцоог боловсронгуй болгож, нийгэм-эдийн засгийн нөхцөл, мэдээллийн шинэ эрин зууны шаардлагад нийцсэн орчин үеийн чанартай боловсрол олгох тогтолцооны үндсэн өөрчлөлтийг тодорхой төслөөр дамжуулан хэрэгжүүлэхэд оршиж байгаа юм. Энэхүү үндэсний төсөлд боловсролын тогтолцоог зайлшгүй өөрчлөх хоёр үндсэн механизмыг багтааж байна. Үүнд: нэгдүгээрт, хүүхэд, залуучууд, иргэдэд амьдрах арга ухааны мэдлэг, чадвар, дадлага эзэмшүүлэх замаар шинжлэх ухаан, технологийн дэвшилд хэвшүүлэх, хоёрдугаарт, боловсролын тогтолцооны өөрчлөлтийг институтуудыг боловсронгуй болгох замаар төдийгүй үр дүн нь тодорхой харагдах бодит үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх явдал юм.

2006-2010 онд “Боловсрол” төслийн хүрээнд 57 их дээд сургууль, 9 мянган инновацийн сургууль, 340 бага болон дунд мэргэжлийн боловсролын байгууллагуудад улсын дэмжлэг үзүүлж, 40 мянган шилдэг багш, 21 мянган авъяаслаг залуучуудыг шагнаж урамшуулан, боловсролын бүх шатны 400 гаруй мянган багшийг жил бүрийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамруулан, боловсролын байгууллагуудад 54,8 мянган сургалтын шинэ тоног төхөөрөмж, 9,8 мянган сургуулийн автобус олгож, 52 мянга гаруй сургууль интернетын сүлжээнд холбогдож, бүх шатны сургуулийн байгууллагуудад сурах үйл ажиллагааг зохион байгуулахад сурагчдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч, галын аюулгүй байдлын тоног төхөөрөмж 2000, видео хяналтын 1200 иж бүрдлээр хангасан байна.<sup>3</sup>

“Холбооны улсын боловсролыг 2015 он хүртэл хөгжүүлэх зорилтот хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр дээд, дунд, бага боловсролтсй иргэдийн

дундах ажилгүйдлийн түвшинг 16%-иар бууруулах, боловсролын системийн бүх түвшинд боловсролын болон амралт чөлөөт цагийн шинэ хөтөлбөрийг нэвтрүүлэх, мэдээлэл, холбоо, технcлогийн үр дүнтэй шинэ үйлчилгээг ашиглах, авъяаслаг хүүхдүүдэд зориулсан тусгай хөтөлбөр, санг бий болгох, боловсролын бүх шатны байгууллагуудын үйл ажиллагааны дүрэм, журмыг цогц байдлаар шинэчлэх, улсын ба хувийн түншлэлийн механизмыг хөгжүүлэх замаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж санхүүгийн байгууллагуудын идэвхтэй, бүтээлч оролцоог бий болгох, боловсролын байгууллагуудын аж ахуйн бие даасан байдлыг хангах загварыг боловсруулах юм.<sup>2</sup>

ОХУ нь 2008 оноос “2020 он хүртэлх урт хугацааны нийгэм-эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлалыг” хэрэгжүүлэх шатандаа явж байна. Уг үзэл баримтлалд мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх зайлшгүй нөхцөл бол улсын аюулгүй байдал, иргэдийн тав тухтай амьдрах хүчин зүйл, эдийн засгийн эрчтэй өсөлт, нийгмийн хөгжлийн үндэс болсон боловсролын тогтолцоог шинэчлэх явдал бөгөөд боловсролын тогтолцооны өрсөлдөөн нь технологийн байнгын шинэчлэл шаардаж байдаг глобаль өрсөлдөөн, инновацийг хурдтай эзэмших, эрчтэй хувьсан өөрчлөгдөж байгаа дэлхий нийтийн шаардлага, эрэлтэд хурдан зохицох гол язгуур үндэс болж байна гэжээ.

2010 онд ОХУ-ын эдийн засгийн хөгжлийн яамнаас “2020 он хүртэлх урт хугацааны нийгэм-эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал”-ыг үндэслэн “Инновацийн Орос – 2020” гэсэн 2020 он хүртэлх ОХУ-ын инновацийн хөгжлийн стратегийн төслийг боловсруулан гаргасан байна.<sup>3</sup> Энэхүү төслийн “Боловсролын инновацийн төлөв байдал” хэмээх бүлэгт “инновацийн хүн”-ийг төлөвшүүлэхэд сургуулийн өмнөх насны боловсролоос эхлэх хэрэгтэй гэж үзэж байна. Сургуулийн өмнөх насны боловсрол нь хувь хүн төлөвшихөд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд эцэг эхчүүд үр хүүхдийнхээ хүмүүжил, боловсролд анхаарлаа хандуулснаар сурч боловсрох, нийгэмд эзлэх байр сууриа олж авахад ихээхэн тус дөхөм болно гэж үзэж байна. Төрийн зүгээс нийгэмд чиглэсэн арилжааны

бус байгууллагуудын үйл ажиллагааны тогтолцооны хүрээнд гэр бүлийн хүмүүжлийн арга барилын талаар залуу гэр бүлүүдэд үнэ төлбөргүй мэдээлэл хүргэх иргэний нийгмийн институт, бүс нутгийн санаачилгыг дэмжих юм.

Боловсролын шинэчлэлд гарсан дараах дорвитой ажлуудыг дурдаж болно.

2009 онд ерөнхий боловсролын сургуулиудын боловсон хүчний бүтцийг шинэчилснээр залуу мэргэжилтнүүд 10%-ийг эзлэх (өмнөх жилүүдэд 1%-ийг эзэлж байв) болсон байна.

Холбооны улсын боловсролын мэдээллийн төвийн сайтыг үзсэн хүний тоо 2008 онд сард 47000 байсан бол 2009 онд 173000 болж нэмэгдсэн байна.

Боловсролын тогтолцоог шинэчлэх үндсэн механизм, мэдлэгт суурилсан боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд оролцож байгаа бүс нутгийн болон боловсролын байгууллагуудын сүлжээ бүрэлдэн тогтсон байна.

Түүнчлэн Оросын боловсролын тогтолцоог шинэчлэх практикийг нэвтрүүлэх манлайлагчдын бүлэг, өрсөлдөх орчин бий болоод байна.

Оросын боловсролын тогтолцооны өнөөгийн байдлыг харахад өргөн хүрээтэй арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа боловч шийдвэрлэвэл зохистой олон асуудлууд байсаар байна. Оросын боловсролыг хөгжүүлэхэд нөлөөлж байгаа нэг чухал хүчин зүйл бол хүн ам зүйн нөхцөл байдал юм. Сүүлийн 10 жилд дунд сургуулийн сурагчдын тоо ойролцоогоор 40%-иар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2013 онд их дээд сургуулийн оюутнуудын тоо ойролцоогоор 4,2 сая буюу 2009 оныхтой харьцуулахад 40%-иар буурна гэж үзэж байна. Дунд сургууль болон их, дээд сургуулийн багш нарын тоо ч буурах хандлага ажиглагдаж байна. Ойрын жилүүдийн нөхцөл байдлаас харахад дунд сургуулийн багш нарын тоонд энэ үзүүлэлт (нэгдүгээр ангид орох хүүхдийн тоо их байгаагаар холбоотой) төдийлөн ажиглагдахгүй байгаа боловч мэргэжлийн боловсролын сургуулиудын багш профессорын бүрэлдэхүүний тоо 20-30%-иар буурах хандлагатай байна. Үүний зэрэгцээ тэтгэврийн насны багш

нарын эзлэх хувь өндөр байгаа бөгөөд багшийн сургууль төгссөн залуу багш нарын ердөө 30% нь л сургуульд багшлахаар ирдэг бөгөөд 3 жил багшилсны дараа залуу багш нарын зургааны нэг хувь нь боловсролын салбарт ажиллахаар үлддэг байна. Иймээс орчин үеийн лабораторийн тоног төхөөрөмж бүхий холбооны улсын болон үндэсний судалгааны их сургуулиудад чанартай өндөр боловсрол олж авах оюутнуудын тоог нэмэгдүүлэхийн тулд их дээд сургуулиуд болон салбар сургуулиудын тоог бууруулах замаар бүтцийн хэв шинжийн өөрчлөлт хийх шаардлагатай байгаа юм.

Түүнчлэн орчин үеийн боловсролын салбарын нэг чухал асуудал бол боловсролын салбар дахь мэдээлэл харилцаа холбооны технологийг үр ашигтай ашиглах үйл явц юм. Өнөөгийн боловсролын болон удирдан зохион байгуулах практикт мэдээлэл харилцаа холбооны болон боловсролын электрон санг ашиглах явдал төдийлөн хангалттай биш байна. Боловсролын нэгдмэл электрон орчин боловсролын чанарыг дээшлүүлэх хүчин зүйл болж чадаагүй байна. Багш сурагч, оюутнууд шинжлэх ухаан, техникийн талаар үнэн зөв бодитой мэдээлэл авах, электрон сурах бичиг болон бусад эх сурвалжуудыг өргөнөөр ашиглах бололцоог бүрдүүлэхийн тулд техник, технологийн нөхцлийг бий болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар энэ асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

Оросын боловсролын салбарын бас нэг тулгамдсан асуудал бол гоц авъяастай хүүхэд, залуучуудад чиглэсэн системтэй ажил үгүйлэгдэж байна. Энэ ажилд үр ашигтай механизм, тасралтгүй байдал, хүүхдэд нэмэлт боловсрол олгох байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагууд, их, дээд сургуулиудын боломжийг ашиглах явдал дутагдаж байна.

Нийгмийн тэгш бус байдал нэмэгдэх тусам оросын иргэдийн чанартай боловсрол олж авах хүртээмжийн хувьд тэгш бус байдал улам гүнзгийрч байна. Энэ байдал сургуулийн өмнөх шатны боловсролоос эхлэн ажиглагдаж байна.

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд стратегийн өргөн хүрээтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээс гадна төлөвлөгөөт нормативын аргыг хэрэглэх, ингэхдээ улсаас салбарын болон салбарын доторх

хэм хэмжээг тогтоох, тухайлбал, хөдөлмөрийн зардал, цалин хөлс, урсгал болон их засвар, шинэ барилга байгууламжийн зардлыг тогтоож төлөвлөж өгөх нь чухал юм.

**Ашигласан материал:**

1. Концепция долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2020 года.
2. Федеральная целевая программа развития образования на 2011-2015 годы.  
<http://mon.gov.ru/files/materials/8311/11.02.07-fcpro.pdf>
3. Концепция Федеральной целевой программы развития образования на 2011-2015 годы. <http://mcn.gov.ru/files/materials/8182/11.02.07-fcpro.k.pdf>
4. Выступление Президента России Владимира Путина на встрече с членами Правительства, руководством Федерального Собрания и членами президиума Государственного совета 5 сентября 2005 г./ <http://mon.gov.ru/pro/pnpro/4156/>
5. Инновационная Россия – 2020. (Стратегия инновационного развития Российской Федерации на период до 2020 года).М. 2010.